

**БАТЛАВ**  
**БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН**  
**ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ**  
**ЗАХИРАЛ** **Н.МӨНГӨНХӨЛӨГТ**




**“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН**  
**СТРАТЕГИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ**  
**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДААЛГАВАР**

№	Ажлын нэр	Тайлбар
1	Үйлчилгээний нэр	“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн стратегийн баримт бичиг боловсруулах
2	Захиалагч газар, хэлтсийн нэр	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс
3	Үйлчилгээг хэрэгжүүлэх үндэслэл, хэрэгцээ шаардлага	<p>Тус компани нь нийслэлийн Багануур дүүрэг, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь аймгуудын төв, 7 аймгийн 58 сум, суурин газрын 276.6 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэр дэх 53.3 мянган хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, түгээх үйл ажиллагааг эрхэлдэг 100 хувь төрийн өмчит хаалттай хувьцаат компани юм.</p> <p>Иймд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2 дугаар зүйл болох “Эрчим хүчний сэргэлт”-ийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудтай уялдуулан компанийн хөгжлийн стратегийг тодорхойлон баримт бичгийг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.</p>
4	Үйлчилгээний зорилго	“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн үйл ажиллагаа, онцлогт нийцсэн 2024-2030 оны стратегийн зорилгыг Монгол Улсын төрийн бодлого, хууль тогтоомж, эрчим хүчний салбарын өнөөгийн болон ирээдүйн чиг хандлагатай уялдуулж, судалгаа шинжилгээнд үндэслэн, олон улсын жишигт нийцүүлэн тодорхойлж, баримт бичгийг боловсруулах
5	Үйлчилгээний хамрах хүрээ	<p>Стратегийн баримт бичгийг боловсруулах үйлчилгээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Баримт бичгийн шинжилгээ <ul style="list-style-type: none"> <li>- Эрчим хүчний салбарт ашиглагдаж буй бодлого, төлөвлөлтийн баримт бичиг</li> <li>- Эрчим хүчний салбарт баримталдаг хууль, дүрэм, журам</li> <li>- Хамааралтай бусад баримт бичиг</li> </ul> </li> <li>2. Хоёрдогч болон анхдагч тоон болон чанарын судалгаа, шинжилгээ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Макро болон мезо орчны шинжилгээ</li> <li>- Бүтэц, зохион байгуулалтын шинжилгээ</li> <li>- Эрсдэлийн шинжилгээ</li> <li>- Үр дүнгийн шинжилгээ</li> <li>- Бусад шаардлагатай судалгаа, шинжилгээний</li> </ul> </li> </ol>

		<p style="text-align: center;"><b>ажлууд</b></p> <p>3. Компанийн эрхэм зорилго, алсын хараа, уриа, үнэт зүйлсийг тодорхойлох</p> <p>4. Компанийн 2024-2030 оны стратегийн зорилгыг тодорхойлох. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үндэслэл</li> <li>- Зорилт</li> <li>- Үйл ажиллагаа</li> <li>- Шалгуур үзүүлэлт</li> <li>- Хүрэх үр дүн</li> <li>- Зураглал</li> <li>- Бүтэц зохион байгуулалт ба стратегийн зорилгын уялдаа</li> </ul> <p>4. Стратегийн зорилгын биелэлтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт-үнэлгээ хийх арга зүй</p> <p>5. Дүгнэлт, зөвлөмж</p> <p>6. Боловсруулсан стратегийн баримт бичгийн хүрээнд компанийн холбогдох албан тушаалтнуудад сургалт хийх</p>
6	<p>Үйлчилгээг гүйцэтгэгч талд тавигдах шаардлага</p>	<p><b>Гүйцэтгэгч тал нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний үр хэрэгжилтийн үр дүнд судалгаа, шинжилгээ хийж зөвлөмж боловсруулсан туршлагатай байна.</li> <li>2. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн өнөө болон ирээдүйн нөхцөл байдлыг системийн хүрээнд, цогц байдлаар загварчилж, олон улсын чиг хандлага, үндэсний болон салбарын бодлого, төлөвлөлтийн нөлөөг үнэлэн, ирээдүйн талаар таамаглал, прогноз гаргах чадвар, туршлагатай байна.</li> <li>3. Баг 5-аас доошгүй гишүүнтэй байх ба мэргэжил, боловсрол, туршлагын хувьд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:</li> </ol> <p><b>Багийн ахлагч:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засаг, бизнесийн менежментийн мэргэжилтэй байх.</li> <li>- Төрийн болон төрийн өмчит байгууллагад судалгаа, шинжилгээний ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан 10 (арав)-аас доошгүй жилийн туршлагатай байх</li> <li>- Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагад удирдах албан тушаалтнаар 5 (тав)-аас доошгүй жил ажилласан байх</li> <li>- Судалгаа шинжилгээ болон бодлогын баримт бичиг боловсруулах ажилд оролцож байсан 5 (тав) ба түүнээс дээш жилийн ажлын туршлагатай байх</li> <li>- Улсын болон салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр бүтээл туурвисан туршлагатай байх</li> <li>- Тухайн сэдвийн хүрээнд гадаад улс, олон улсын байгууллагын туршлагыг судлах гадаад хэлний өндөр</li> </ul>

		<p>мэдлэгтэй (IELTS, TOEFL-ийн оноо эсвэл гадаадад сургууль төгссөнийг нотлох) байх</p> <p>Багийн гишүүд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Бодлого, стратегийн чиглэлийн мэргэжилтэн</li> <li>2. Эрчим хүчний салбарын мэргэжилтэн</li> <li>3. Санхүү, эдийн засагч</li> <li>4. Дата аналит</li> </ol> <p>Багийн гишүүд нь мэргэжлээрээ буюу тухайн салбартаа 5-аас дээш жил ажилласан туршлагатай, судалгаа, шинжилгээ, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай, доктор буюу түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байх.</p>
7	Тайлангийн хуваарь	<p>Дараах хуваарийн дагуу тайлан боловсруулж ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Явцын тайлан: Гэрээ байгуулснаас хойш 45 хоногийн дотор захиалагчид ирүүлнэ.</li> <li>2. Гүйцэтгэлийн тайлан: Үйлчилгээний даалгаварт заасан ажлуудыг бүрэн дуусган компанийн 2024-2030 оны стратегийн баримт бичиг, гүйцэтгэлийн тайланг гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор захиалагчид хүлээлгэн өгснөөр ажлын хугацаа дуусгавар болно.</li> </ol>

БОЛОВСРУУЛСАН:  
ЗХНХ-ИЙН ДАРГА

 Я.ОТГОНЗУЛ